



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 8/99

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан боловсруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын “Журам шинэчлэн батлах тухай” 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажил үүргийн хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн дотор хэлэлцүүлж, 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэхийг ажлын хэсэг (Ц.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0207

Аймгийн Засаг даргын 2024 оны... дугаар  
сарын...-ны өдрийн... дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ  
ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Н.Энхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Р.Цэрэндэжид (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн Ахлах мэргэжилтэн)

Д.Мөнхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Н.Гуамарал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Л.Ишханд (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Н.Дулам (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Х.Мөнхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)


Н.Осоржин (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Мэргэжилтэн)

Г.Нямсүрэн (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Мэргэжилтэн)

А.Чанцалдулам (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Т.Үржинпүрэв (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 1179 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд дараах зохион байгуулалтаар 2023 оны жилийн эцсийн тайланг үнэлж, дүгнэн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлнэ.

1. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн: Тайланг холбогдох хэлтэс (газар)-ээс нэгтгэн авч, мэдээллийг нягтлан шалгаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэлтсийн даргад танилцуулна.

2. Хэлтсийн дарга: Тухайн тайланг нягтлан шалгаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Тайланг хянаж, үнэлгээ өгнө. Хэрэв тайлангийн мэдээлэл, чанар хангалтгүй гэж үзвэл бодлогын хэлтсүүдээс дахин тодруулга авч үнэлгээг гаргана.

4. Ажлын хэсгийн ахлагч: Тайланг нягтлан хянаж, үнэлгээг 2024 оны 02 дугаар сарын 28-ны дотор эцэслэн баталгаажуулна.

Үзүүлэлт		Хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гаргах	Тайлан хүлээн авч хянах
Хугацаа		2024 оны 02 дугаар сарын 20-ны дотор	2024 оны 02 дугаар сарын 26-ны дотор
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	2024 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт гаргах- Л.Ишханд (ХШҮХ-ийн ахлах мэргэжилтэн)	
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	2024 оны 01 дүгээр сарын 1-ний өдөр Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулж, баталгаажуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт гаргах- Н.Гуамарал (ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн)	
	3. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр тайланг байршуулж, баталгаажуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт гаргах- (ХБТХОХ-ийн мэргэжилтэн Н.Осоржин)	
	4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулж, баталгаажуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт гаргах- Н.Гуамарал (ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн)	

	5.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	Т.Үржинпүрэв (ХШҮХ-ийн дарга)	Ц.Ганболд (ЗДТГ-ын дарга)
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	Гэрээний хэрэгжилт, үр дүнгийн тайланг заасан хугацаанд холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлсэн. Гэрээний үүргийн биелэлтийн дүгнэлт гаргах- А.Чанцалдулам (ТЗУХ-ийн мэргэжилтэн)	
	2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор тайланг байршуулж, баталгаажуулна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт гаргах- Г.Нямсүрэн (ХШҮХ-ийн мэргэжилтэн)	
	3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	Х.Мөнхцэцэг (ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн)	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдал	Х.Мөнхцэцэг (ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн) А.Чанцалдулам (ТЗУХ-ийн мэргэжилтэн)	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)
	2.Шилэн дансны хөтөлөлт	Р.Цэрэндэжид (СТСХ-ийн ахлах мэргэжилтэн)	Т.Үржинпүрэв (ХШҮХ-ийн дарга)
	3.Шударга байдлын түвшин	Д.Мөнхцэцэг (ХЭЗХ-ийн ахлах мэргэжилтэн)	Т.Үржинпүрэв (ХШҮХ-ийн дарга)
Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт	Н.Дулам (ХБТХОХ-ийн ахлах мэргэжилтэн) А.Чанцалдулам (ТЗУХ-ийн мэргэжилтэн)	Ц.Ганболд (ЗДТГ-ын дарга)

Нэгдсэн тайлан	Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны нэгдсэн тайлан, илтгэх хуудас	Дээрх мэргэжилтнүүд өөрсдийн хариуцсан бодлогын баримт бичиг, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үр дүнгийн талаар хяналт-шинжилгээний тайлан бэлтгэнэ.	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)  Т.Үржинпүрэв (ХШҮХ-ийн дарга)
	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн тайлан, зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан	Л.Ишханд (ХШҮХ-ийн ахлах мэргэжилтэн)	Т.Үржинпүрэв (ХШҮХ-ийн дарга)